

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-10

<i>1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	3-6
<i>2. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох</i>	6-10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 43 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн;

Тасалсан: Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Н.Ганибал.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн газрын ахлах шинжээч М.Солонго, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Э.Батшугар: Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 11 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 25 минут үргэлжилж, ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 43 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Э.Батиугар: Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Н.Учрал гишүүн 28 дугаар тойрог, Э.Батиугар гишүүн 28 дугаар тойрог, Т.Доржханд гишүүн 29 дүгээр тойрог, Ц.Идэрбат гишүүн 18 дугаар тойрог, Б.Саранчимэг гишүүн 22 дугаар тойрог, Ж.Чинбүрэн гишүүн 23 дугаар тойрог. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 54,5 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа. Эхнийх нь Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл төслүүд. 2 дахь асуудал бол Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн алга байна.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудал руу оръё. Төсөл санал илтгэгчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд эдийн засгийн тэргүүлэх 16 чиглэлд мэдээллийн технологийн салбарыг хамааруулж, тус салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх, гадаадын зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн антрепренёр гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, үндэсний тоон контентыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улс НҮБ-аас 2 жил тутам шинэчлэн гаргадаг Цахим засаглалын хөгжлийн индексээр 2020, 2018 онуудад тус байгууллагын гишүүн 193 орноос 92 дугаар байранд орж байсан бол 2022 онд 74 дүгээр байранд орж 18 байраар урагшилсан. Харин дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг улс орнуудын инновацийн чадавх амжилтаар нь эрэмбэлдэг Дэлхийн инновацийн индексээр 2022 онд 71 дүгээр байр эзэлж өмнөх онуудаас 10 гаруй байраар хойшилж, 2023 онд 132 улсаас 68 дугаар байранд жагслаа. Статистик мэдээллээс харахад мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа хувь нэмэр 0,24 хувь байна. Энэ нь мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ихэнх нь дэлхийн бусад улс орны энэ чиглэлээр үйл

ажиллагаа явуулж байгаа компаниудтай харьцуулахад бүрэн төлөвшиж амжаагүй, манай улсад инновац нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэлтийг дэмжих хөрөнгө оруулалтын талаарх хууль, эрх зүйн таатай орчин бүрдээгүй, төрөөс үзүүлэх дэмжлэг хангалтгүй байгаатай холбоотой байна.

Мэдээллийн технологийн хөгжил нь инновацыг идэвхжүүлж, тухайн салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ашиг тус, үр шимээ өгч, цахим эдийн засгийг бий болгон энэ нь нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, бүтээмжийг нэмэгдүүлэн, өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийг авчирч байна. Тухайлбал Бүгд найрамдах Казахстан улс 2000-гаад оноос хойш мэдээллийн технологийн салбарт дэмжлэг үзүүлэх хууль, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч дижитал Казахстан улсын хэмжээний хөтөлбөрийг 2017 оноос хэрэгжүүлж, 655 сая гаруй америк долларын хөрөнгө оруулалтыг зарцуулсан байна. Тус улс нь 2017 онд Дижитал Казахстан хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжлийн түвшинээр 175 орноос 52 дугаар байранд жагссан.

Түүнчлэн Бүгд найрамдах Солонгос улсын мэдээлэл харилцаа холбооны технологийн салбар нь 2022 онд Солонгосын дотоодын нийт бүтээгдэхүүний 13 хувийг бүрдүүлж улсын эдийн засгийн өсөлтийг тэргүүлж байна. 2022 онд мэдээллийн технологийн экспорт 233,3 тэрбум ам.доллар-т хүрч, мэдээлэл харилцаа холбооны технологийн салбар дахь үйлдвэрлэл нь нийт экспортын 30-аас 40 хувийг эзэлж, улсын эдийн засгийн өсөлтөд томоохон хувь нэмрийг оруулж байна. Бүгд найрамдах Турк улс 2023 онд Үндэсний технологи хүчирхэг үйлдвэрлэл гэсэн алсын хараатай стратегийн баримт бичгийг боловсруулан баталж, Турк улс

даяар программ хангамж хөгжүүлэгчдийн тоог 140 мянгаас 500 мянгад хүргэхээр, дор хаяж 23 ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх зорилтыг дэвшүүлжээ. Энэ хүрээнд гарааны бизнес эрхлэгчид болон ААН-үүдэд үзүүлэх төрийн дэмжлэгүүдээс ашиг хүртэх арга замыг Технологийн хөгжлийн бүсийн тухай хуулиараа зохицуулж, тус бүсэд бүртгүүлэн нэмэгдсэн өртгийн орлогын болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөх, нийгмийн даатгалын шимтгэлийн дэмжлэг авах зэрэг олон тооны боломжуудыг олгожээ.

Иймд Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан мэдээллийн технологийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийг дэмжих зорилтын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын ЗГ-аас Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийн дэмжих тухай хуулийн төслийг санаачлан боловсруулан танилцуулж байна.

Хуулийн төслийн 1 дүгээр бүлэгт хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээг тогтоож, хуульд хэрэглэсэн зарим нэр томъёог тодорхойллоо. Энэ хүрээнд сэндбокс орчны талаар тодорхойлж, хиймэл оюун ухаан, эх өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбокс-н орчин бий болгон холбогдох журмыг ЗГ батлахаар тусгалаа. Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, тэр дундаа мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах, төр, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс татгалзах, мэдээллийн технологийн үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх дэмжлэгийг ил тод, шударга, нээлттэй байх талаар тогтоолоо.

Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт салбарын бодлого чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн холбоо, хувийн хэвшил, мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх, Монгол Улсын ЗГ Цахим хөгжил, харилцаа холбооны яам, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүлээх үүргийг тогтоож, салбар хоорондын уялдаа холбоог хангах, Мэдээлэл технологийн үндэсний паркийн чиг үүргийг тодорхой болгож, гарааны бизнесийг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар тусгалаа. Түүнчлэн төрийн байгууллага нь худалдан авсан программ хангамжийн эх кодын эзэмших эрхийг харилцан тохиролцож, тендер шалгаруулалтын баримт бичигт заахаар, Мэдээллийн технологийн үндэсний парк нь виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр зохицууллаа.

Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэх, тавигдах шаардлага, бүртгэлээс хасах үндэслэлийг тодорхойллоо.

Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг, дэмжлэгийн эх үүсвэрийн талаар тусгалаа.

Хуулийн төслийн 5 дугаар бүлэгт Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан хориглох зүйл, хууль зөрчигчдөд хүлээлгэх

хариуцлагатай холбоотой бусад зүйлийг тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Э.Батшугар: Ажлын хэсгийг танилцуулъя. Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Сүрэнхорол Цахим хөгжил харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Солонгоо Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын цахим хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Алга байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя. Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлал баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт 57,1 хувиар дэмжигдлээ. Мэдээлэл технологи үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх танилцуулгыг явуулж дууслаа.

Хуулийн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, чуулгын

нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ундрам танилцуулна.

10.53 цаг

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох

Дараагийн асуудалдаа оръё. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бич бичгийн дарга, Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Батбаатар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга, Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Эрдэнэбулган ирсэн үү? Бат-Идэр ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын ахлах референт.

Тогтоолын хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Учрал Танилцуулна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 5 дугаар тогтоолоор цахим шилжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын ЗГ-т даалгасны дагуу эрхлэх асуудлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж

авах солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх. Хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгах талаар хуулийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн А97 дугаар тушаалаар шүүн таслах ажиллагаа нээлттэй, ил тод байдлыг сайжруулах болон төрийн цахим шилжилттэй уялдуулан шүүхийн цахимжилтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Уг ажлын хэсгийн хүрээнд иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах, шүүх хүлээн авах, шүүхээс гаргаж байгаа аливаа шийдвэрийг хариуг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр мэдэгдэх, шүүх, төрийн бус, төрийн бусад байгууллагын хадгалж ашиглаж байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байна.

2.Кибер аюулгүй байдлын хуульд заасан онц чухал мэдээллийн дэд

бүтэцтэй болон холбогдох бусад байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, чанарын менежментийн тогтолцоо, бизнесийн тасралтгүй байдлын менежментийн тогтолцоо, хүний хувийн мэдээллийг хамгаалах менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг олон улсын ISO 27001 болон NIST SP стандартын дагуу боловсруулж, Монгол Улсын ЗГ-ын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан.

Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 156 байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийсэн тайланг Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Үндэсний төв, Зэвсэгт хүчний төвд тус тус хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллага болон төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагын удирдах түвшний болон мэдээлэл технологийн албан хаагчдад кибер аюулгүй байдлын тогтолцоо, хууль, эрх зүйн орчин, кибер аюулгүй байдлын төлөвлөлтийн загвар стандарт, эрсдэлийн удирдлагын хүрээ, кибер халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах зэрэг сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, 2023 онд 35 байгууллагын 505 албан хаагч, 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 72 байгууллагын 255 албан хаагчийг тус тус хамруулаад байна.

3. Зэвсэгт хүчний Жанжин Штабын Кибер аюулгүй байдлын цэргийн командлалтай хамтран кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх ITASTIC команд штабын хамтарсан сургалтыг Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд зохион байгуулж, 7 байгууллагын 80 албан хаагчийг хамруулаа. Мөн кибер

халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвд харьяалагдах онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 25 байгууллагын 100 албан хаагчийн дунд кибер халдлагаас хамгаалах нь сэдвийн хүрээнд цахим сургалтуудыг зохион байгууллаа. Мөн иргэдийн цахим ур чадвар, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 21 аймаг, 9 дүүрэгт сургалт зохион байгуулан ажиллаж байна.

Хүний эмзэг мэдээлэл генетик болон биометрик мэдээллийг боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журмыг тус тус Европын холбооны хувийн өгөгдөл хамгаалах тухай жишиг загвар, Европын холбооны хувийн өгөгдөл хамгаалах ажлын хэсгээс гаргасан хувийн өгөгдөл хамгаалахад нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу боловсруулж, 2023 оны А81, А90 дүгээр тушаалаар баталлаа.

3. Үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх үүднээс төрд байгаа гааль, татвар, санхүүгийн болон бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр нээлттэй өгөгдөл болгох, нээлттэй өгөгдлийг хиймэл оюун ухааны тусламжтай болон бусад хэлбэрээр боловсруулж ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах. Төрийн байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд нэгдсэн үзлэг шалгалтыг 2024 онд багтаан хийж, давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын ЗГ мэдээлэл технологийн дэвшилийг үйл ажиллагаандаа оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн боломжийг бий болгох, баялаг бүтээх, инновацыг дэмжих зорилгоор төрийн

өгөгдлийг хүн, хуулийн этгээдэд нээлттэй ашиглуулах зорилгоор төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал opendata.gov.mn 2.0 хувилбарыг 2024 оны 3 дугаар сарын дараа 7-ны өдөр нэвтрүүлээ.

Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох нийтлэгт тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам болон нээлттэй өгөгдлийн жагсаалтын дагуу мэдээлэл хариуцагч байгууллага мэдээллийг нийтлэх хугацаа болсон талаар мэдэгдэл очих, тайланг нийт өгөгдлийн түвшинд боломжит хэлбэрээр харуулах, хянах самбар, *dashboard*-н үзүүлэлт, санал хүсэлтийн модулийг шийдвэрлэсэн зэрэг үйлдэл ашиглалтад орсноос хойш 64829 удаа өгөгдөл татаж, 471527 хандалт аваад байна. Нээлттэй өгөгдлийн жагсаалтыг төрийн 59 байгууллагын 606 өгөгдлөөс гадна төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд уул уурхайн компани иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс шинээр бий болгох нээлттэй өгөгдлийн талаар санал хүсэлтийг авч, нээлттэй өгөгдлийн жагсаалтад нэмж оруулахаар ажиглаж байна.

3.2.Төрийн байгууллагын бүрдүүлж ашиглаж байгаа өгөгдөл мэдээллийг нэгтгэн нөхцөл байдлыг дүгнэх, үнэлгээний үр дүнд их өгөгдөл бий болгоход шаардлагатай арга хэрэгслийг тодорхойлох зорилгоор төрийн 38 байгууллагын 75 өгөгдлийн санг судалгаанд хамруулахад эдийн засгийн, нийгмийн хамгааллын, байгаль орчны, шинэчлэл ухааны чиглэлийн цахим үйлчилгээ, хяналт, тайлан, мэдээ, судалгаа шинжилгээний гэсэн нийтлэг зорилгоор ашиглагдаж байна. Эдгээр өгөгдлийн сангуудад давхардсан тоогоор нийт 8604 үзүүлэлт байгаагаас 1116 задаргаа бүхий утга, 7488 үзүүлэлт нь текст тоон болон огноо гэсэн утга тус тус авч байгаа бөгөөд үзүүлэлтүүдийг нийтлэг агуулга утгаар нь бүлэглэн харвал нийт 8604 үзүүлэлт нь 361 агуулгад багтаж, хамгийн их давхардаж байгаа агуулгад түлхүүр дугаар, нэр,

хугацаа, төрөл код, байршил, баталгаажуулалт, дэлгэрэнгүй хаяг төлөв гэсэн үзүүлэлтүүд илэрлээ.

Мөн регистрийн дугаар бүхий үзүүлэлт 26 байгууллагын 44 өгөгдлийн санд агуулагдаж байгаа нь эдгээр санг хооронд нь уялдуулах холбох боломжтой байна. Иймд мэдээллийн сангийн өгөгдөл мэдээллийг солилцоход мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгон төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулах нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр их өгөгдлийн сан үүсгэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын тогтолцоог бүрдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэж, ЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 403 дугаар тогтоолоор их өгөгдлийн санг үүсгэх тухай тогтоол баталсан.

3.3.Төрийн байгууллага хуульд заасан эрх, үүргийн хэмжээнд салбарын анхдагч мэдээлэл бүрдүүлэх, бүртгэх, хөгжүүлэх чиглэлээр мэдээллийн санг бүрдүүлж ирсэн бөгөөд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудад 187 нийслэл, орон нутаг, тэдгээрийн салбар харьяа байгууллагуудад 53 нийт 240 мэдээллийн систем, программ хангамж, мэдээллийн сан байна. Эдгээр мэдээллийн сангийн бүтэц хадгалж, ашиглаж байгаа мэдээлэл, өгөгдлийн төрлүүдийг тодорхойлсон нэгдсэн бүртгэл мэдээллийн сан одоогоор бүрдээгүй байна. Бусад улсын туршилагаас харахад харилцан уялдаатай холбогдсон өгөгдлийг нэн тэргүүний зорилт болгон үндэсний стратеги хөтөлбөрт тусгаж, аюулгүй нийтлэг протоколоор дамжуулан тогтмол ашиглагддаг мэдээллийн форматаар өгөгдөл солилцох нөхцөлийг бүрдүүлэн ажиглаж байна. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журмыг ЗГ 2024 оны 77 дугаар тогтоолоороо баталсан.

3.4.2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр нээлттэй мэдээллийн нэгдсэн систем *shilen.gov.mn 2.0* хувилбарт хувийн хэвшилтэй хамтран хиймэл оюун ухааны технологи дэвшилийг нэвтрүүлээ. Өнөөдрийн байдлаар хиймэл оюун ухааны технологид ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг мэдээллийн санг сургаад байна. Төр өөрт байгаа мэдээллээ хиймэл оюун ухаанд сурган ажиглуулж эхэлсэн нь авлигын эсрэг тэмцэлд дэвшилтэт технологи ашиглаж иргэний Монгол Улсын Үндсэн хуульд заасан мэдэх эрхийг ханган эрүүл, нээлттэй нийгэм бүтээх зорилтыг хэрэгжүүлэхэд иргэд сонирхож буй мэдээллээ илүү хурдан, хялбар авах боломжтой болсон. Хиймэл оюуныг дараагийн удаад газар олголт, ЗГ-ын тусгай сангуудын талаарх асуултад хариулдаг байдлаар сургахаар ажлын бэлтгэлийг хангаж байна.

4. Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих, ДНБ мэдээлэл технологийн салбарын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, туршилага, ноу хау нэвтрүүлэхийг дэмжсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

6. Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горилмоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах ажлын хүрээнд хөдөө орон нутаг, алслагдсан сум, суурин газар болон хилийн чанадад байгаа ард иргэд, байгууллагуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас төрийн үйлчилгээний хурдан цэгийг нийт 175 байршилд нийслэлд 66, орон нутагт 82, хилийн чанад дахь 20 улс, 29 улсын 44 байршилд, хилийн 1 боомтод тус тус нээж, 43 байгууллагын 478 үйлчилгээг

нийт 503860 хүн, хуулийн этгээдэд үзүүлээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нийслэлийн ЧД-ийн 24 дүгээр хороо, Хан-Уул дүүргийн 25 хороо, СБД-ийн хороод, БЗД-ийн 2 хороо нийт 55 хороонд, орон нутгийн хэмжээнд Хөвсгөл аймагт 2, Дорнод аймагт 2, Дархан-Уул аймагт 3, Орхон аймагт 1 төрийн үйлчилгээний хурдан цэг буюу орон нутгийн хэмжээнд нийт 8, улсын хэмжээнд 63 цэгийг байгуулан ажиллаж байна. Цаашид тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн үйлчилгээний аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороо бүрд төрийн үйлчилгээний хурдан цэгийг байгуулан иргэндээ ойртсон төрийн үйлчилгээг хүргэхээр зорилт тавин ажиллаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Э.Батшугар: Учрал сайдад баярлалаа. Тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Тэгэхээр би нэг юм асууя ажлын хэсгээс асууя. Энэ тогтоол дээр бол нэг чухал заалт байгаа. Тэр нь болбол төр өөртөө байгаа мэдээллийг иргэн болон ААН-ээс асуухгүй гэж байгаа юм. Өнөөдрийн байдлаар болбол шаардахгүй. Тэгэхээр өнөөдрийн байдлаар болбол энэ их төвөг үүсгэдэг, хүнд суртал үүсгэдэг. Жишээлбэл Монгол Улсын иргэн тэтгэвэрт гарах гэж байна гэвэл олон олон байгууллагаас бичиг цаас хөөцөлдөж явдаг. Жишээлбэл дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс гэх мэтчилэн. Тэгэхээр одоо яг тогтоолтой холбоотойгоор яг энэ заалт амилсан уу, хэрэгжиж эхэлж байгаа юу гэж асууя.

2 дугаар асуулт болбол энэ дотоодын роумингийн үйлчилгээг нэвтрүүлэх дэд бүтцийг бий болгоно гэсэн. Гэхдээ энэ ажил аль шатдаа явж байгаа вэ? 2 асуулт байна, баярлалаа. 2 номерын микрофоныг нээе. 2 номер.

Б.Батцэцэг: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Батиугар гишүүний асуултад хариулъя. I дүгээр асуултын хувьд бол бид нар төрд, төр өөрт байгаа мэдээллээ иргэдээс нэхэхгүй байх гэдэг дээр бас нөгөө холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан уулзалтуудыг хийж, хэрэгжилтийг зохион байгуулахад бол онцгой анхаарч ажиллаж байгаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай бид нар уулзалт хийсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр нөгөө салбарын процессын ре-инженерчлэлд орсонтой холбогдуулан түүний үр дүнг хэрэгжүүлэх зорилгоор бол бид нар ИМонгол аппликэйшнд тодорхой төрлийн үйлчилгээнүүдийг нь холбох, яг энэ салбарт байгаа мэдээллийн нэгдсэн санд байгаа мэдээллүүдийг саадгүй солилцох чиглэлийн ажлуудыг бол зохион байгуулалтыг хангаад ажиллаж байна.

Дотоодын роумингийн үйлчилгээ нэвтрүүлэх асуудал Харилцаа холбооны хуулийн бид нар нэмэлт, өөрчлөлт оруулахаар ЗГ-т боловсруулаад өгсөн байж байгаа. Энэ хуулийн төсөл Засгийн газраар хараахан хэлэлцэгдээгүй байгаа. Тэгэхээр одоогоор бол ямар нэгэн ажил хийгдээгүй. Энэ хуулийн төсөл батлагдах юм бол энэ дээр холбогдох зохицуулалтууд байгаа.

Төр иргэдээсээ мэдээлэл шаардахгүй, өөрт байгаа мэдээллээ шаардахгүй байх асуудал хуулийн зохицуулалт гэхээсээ илүүтэйгээр бас арга хэмжээг энэ ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч дээр ойлголт, ойлголтын өөрчлөлт оруулах ажлууд бас

асар чухал байна. Энэ хүрээнд бид нар, мөн ИМонгол академи, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар маань тасралтгүй төрийн байгууллагуудад энэ цахим ур чадварын төрийн үйлчилгээг цахимаар хүргэхтэй холбоотойгоор Цахим хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор сургалтуудыг бол хийгээд явж байгаа. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 109 хууль батлагдсантай холбоотойгоор бас мөн салбар салбарын байгууллагуудын төрийн албан хаагчдад чиглэсэн мэдээлэл таниулах сургалтуудыг бол бас тасралтгүй хийгээд явж байна.

Э.Батиугар: Баярлалаа. Төрийн нарийн бичгийн даргад баярлалаа. Тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуулт авч, хариулт авч дууслаа. Тогтоолын хэрэгжилттэй холбоотой санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаар сонслоо.

11.08 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа. Мөн ажлын хэсэгт бас баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

